



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын эрүүл мэндийн төвийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 147

танай _____ ны № _____ т

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Т.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж эмнэлэгийн тусламж үйлчилгээг 4 арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 644,980.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 644,434.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнэ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон тавилга эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, програм хангамжийг акталж, данснаас хасах асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагатай хөрөнгө бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны А/01 тоот захирамжаар 23 орон тоотой бүтцийг батлуулж, гүйцэтгэлээр 22 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

006020340

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт		2022.12.31	2023.12.31
		1	.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	235,457.5	271,819.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	300,474.1	349,991.7
	Нийт хөрөнгийн дүн	535,931.6	621,810.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	535,931.6	621,810.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	535,931.6	621,810.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	888,099.6	815,486.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	673,233.0	729,807.8
	Үйл ажиллагааны үр дүн	214,866.6	85,679.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	(4,295.8)	200.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	210,570.9	85,879.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325,360.8	535,931.6
	Тайлант оны үр дүн	210,570.9	85,879.1
	Эцсийн үлдэгдэл	535,931.6	621,810.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	789,868.8	744,699.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	570,937.8	660,283.4
	Үйл ажиллагааны ЦМГ	218,930.9	84,416.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(21,399.8)	(71,872.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	197,531.1	12,544.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,707.5	200,238.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	200,238.6	212,782.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	726,358.1
	Урсгал зардал	-	726,358.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	738,902.1
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 78,564.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 78,564.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын газар буюу биет бус хөрөнгийг бүртгэлд тусгаагүй 6,692.0 мянган төгрөгийн газрын бүртгэлд тусгаж залрууллаа.

Төвлөрүүлэх шилжүүлгийн зардал, хөрөнгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлаар бүртгэсэн нь УСНББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 71,872.0 мянган төгрөгийг залруулав.

Аудитаар нийт 9,654.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,750.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 404.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1 төлбөрийн акт, 2 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 443.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлаас улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан дарга, нягтлан бодогчид балансын урамшуулал, статистик эмчид тайлангийн урамшуулал нийт 2,750.9 мянган төгрөгийг зориулалт бусаар олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан 2,750.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын тайланд шатахуун үлдэгдлийг бүртгэхдээ нэгжийн үнэ 1000 төгрөгөөр 404 литр гэж нэгжийн үнэ, тоо хэмжээг өөрчилж бүртгэлд тайлагнасан нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгчээс ирсэн анхан шатны баримтын дүнгээр бүртгэлд тусгаж, НББ-ийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг хийж хэвших.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайлангийн 39203, 39205, 39207 дансанд анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн буюу 0 үлдэгдэлтэй 26 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар, ТӨБГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр байгууллагын үндсэн хөрөнгийн тайланд бүртгэлд байгаа анхны өртгөөрөө элэгдлээ нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хасах, ашиглаж байгаа бол үнэ шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын газар буюу биет бус хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.	1	6,692.0	1	6,692.0								
Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардлыг тохируулах бичилт хийж, урсгал зардлаар тайлагнаагүй.	1	71,872.0	1	71,872.0								
Дүн	2	78,564.0	2	78,564.0								

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улирлын үр дүнгийн урамшууллыг цалингийн зардлаас жилийн дүнгээр хэтрүүлэн, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон.	1	2,750.9	1	2,750.9								
Бараа материалын тайланд шатахуун үлдэгдлийг бүртгэхдээ нэгжийн үнэ 1000	1	404.0					1	404.0				

төгрөгөөр 404 литр гэж нэгжийн үнийг өөрчилж бүртгэлд тайлагнасан.												
Үндсэн хөрөнгийн тайлангийн 39203, 39205, 39207 дансанд анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн буюу 0 үлдэгдэлтэй 26 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй.	1	6,500.0					1	6,500.0				
Дүн	3	9,654.9	1	2,750.9			2	6,904.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 281,100.0 мянган төгрөгийн 8 гүйлгээг мэдээлээгүй, 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	281,100.0					1	281,100.0
Дүн	1	281,100.0					1	281,100.0
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	281,100.0					1	281,100.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв	1	1			1			
	ТШЗ-ийн дүн	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			